



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/174

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2, 32.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Үр хөндөлтийг зохицуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Журмыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангах, хүний нөөцийг чадавхжуулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газар (М.Наранпүрэв), Эрүүл мэндийн хөгжлийн төв (М.Одгэрэл), Эх барих, эмэгтэйчүүд судлалын мэргэжлийн салбар зөвлөл (Д.Мөнхцэцэг)-д тус тус үүрэг болгосугай.
4. Үр хөндөлтийн хор уршиг, аюултай үр хөндөлтөөс сэргийлэх талаар мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг эрчимтэй зохион байгуулахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Л.Баттөр), Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Янжмаа)-т даалгасугай.
6. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын “Журам батлах тухай” 2019 оны А/387 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Э.БАТШУГАР

141260964

Эрүүл мэндийн сайдын 2026 оны
.05.. дугаар сарын ..06.. ны өдрийн
.А/17.4.. дугаар тушаалын хавсралт

ҮР ХӨНДӨЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Үр хөндөлтийн эрсдэлээс сэргийлэх, хүндрэлийг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх цогц тусламж, үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэх үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Үндсэн зарчим

- 2.1. Үйлчлүүлэгч төвтэй, нотолгоонд суурилсан, чанартай, аюулгүй тусламж, үйлчилгээ үзүүлнэ.
- 2.2. Эрх тэгш, хүртээмжтэй, хариуцлагатай тусламж, үйлчилгээ үзүүлнэ.
- 2.3. Эмэгтэйн эрх ашиг, сонголт, сэтгэл зүй, соёл, зан заншлыг хүндэтгэн, нууцыг хадгална.
- 2.4. Эмэгтэй, түүний хамтрагч, гэр бүлд эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээллээр хангах, дэмжлэгт орчин бүрдүүлнэ.
- 2.5. Яаралтай тусламж шаардлагатай тохиолдолд хамгийн ойр эрүүл мэндийн байгууллагад үзүүлнэ.
- 2.6. Үр хөндөх ажилбарыг стандарт, эмнэлзүйн зааврын дагуу үзүүлнэ.

Гурав. Удирдлага, зохион байгуулалт

- 3.1. Үр хөндөлтийг жирэмсний хугацаагаар нь эрт ба хожуу гэж ангилна.
 - 3.1.1. “Эрт үеийн үр хөндөлт” гэж жирэмсний эхний 12⁺⁶ долоо хоногийн дотор үр хөврөлийг умайгаас эмнэлгийн аргаар гаргахыг хэлнэ.
 - 3.1.2. “Хожуу үеийн үр хөндөлт” гэж жирэмсний 13 долоо хоногоос 21⁺⁶ долоо хоногийн дотор жирэмслэлтийг эмнэлгийн аргаар таслахыг хэлнэ.
- 3.2. Үр хөндөлтийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага
 - 3.2.1. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн болон эх барих, эмэгтэйчүүд судлалын чиглэлээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг клиникт зөвхөн жирэмсний эхний 9 долоо хоног хүртэлх хугацаанд эх барих, эмэгтэйчүүд судлалын ахлах болон түүнээс дээш зэрэгтэй их эмч эмийн аргаар үр хөндөхийг зөвшөөрнө.
 - 3.2.2. Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг ортой, магадлан итгэмжлэгдсэн эмнэлэгт эмийн болон мэс ажилбараар хийгдэх үр хөндөлтийг жирэмсний эрт болон хожуу хугацаанд хийнэ.

3.2.3. Дээрх заалтад зааснаас бусад эмнэлэгт эмэгтэйн амь насыг аврах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлийн их эмч үр хөндөхийг зөвшөөрнө.

3.3. Хожуу үеийн үр хөндөлтийг мэргэжлийн эмч нарын дүгнэлт, зөвлөгөөний шийдвэрээр дор дурдсан заалтаар зөвхөн Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв II, Амаржих газар, Бүсийн оношлогоо, эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн гэрчилгээтэй их эмч үр хөндөх ажилбарыг хийнэ.

3.3.1. Тухайн жирэмслэлт нь эхийн амь нас, эрүүл мэндэд аюултай болох нь тогтоогдсон;

3.3.2. Ургийн эмгэг нь амьдралд үл нийцэх гажиг болох нь тогтоогдсон;

3.3.3. 18 хүртэлх насны охид өөрөө хүсвэл эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрлөөр;

3.3.4. 40-өөс дээш насны эмэгтэй өөрөө хүсвэл;

3.3.5. Цусан төрөл ойртсон нь нотлогдсон;

3.3.6. Бэлгийн хүчирхийлэлд өртөж жирэмсэлсэн;

3.4. Дээр дурдсан заалтуудаас бусад тохиолдолд жирэмснийг хожуу хугацаанд таслахыг хориглоно.

3.5. Дараахь тохиолдолд үр хөндөхийг түр хойшлуулж, холбогдох эмчилгээг хийсний дараа үр хөндөх ажилбарыг гүйцэтгэнэ. Үүнд:

3.5.1. Эрхтэн тогтолцооны цочмог үрэвсэл болон архаг үрэвсэлт өвчний сэдрэлттэй,

3.5.2. Бөөр, шээсний зам болон бэлэг эрхтэний хурц үрэвсэл оношлогдсон бол.

3.6. Үр хөндөх ажилбар хийсэн эмч тухайн ажилбарын талаар “Үр хөндөлт”-ийн түүхэнд тэмдэглэж, үр хөндөлтийн бүртгэлийн маягтанд бүртгэнэ.

3.7. Эрт үеийн үр хөндөлт хийхийн өмнө эмэгтэйд үр хөндөлтийн талаар таниулж, сонгосон аргаар үр хөндүүлэх зөвшөөрлийг бичгээр авч, “Үр хөндөлт”-ийн түүхэнд хавсаргана.

3.8. Хожуу үед үр хөндөхөд дараахь баримт бичгийг бүрдүүлж, “Үр хөндөлт”-ийн түүхэнд хавсаргана. Үүнд:

3.8.1. Эмч нарын зөвлөгөөний шийдвэр,

3.8.2. Үр хөндүүлэх эмэгтэйн өөрийнх нь, 18 хүртэлх насны охидын эцэг, эх, асран хамгаалагчийн, иргэний эрх зүйн чадамжгүй сэтгэцийн эмгэгтэй эмэгтэйн хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн, хэрэв ар гэргүй бол Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн сэтгэцийн эмчийн хүсэлт, зөвшөөрлийг бичгээр авсан байна,

3.8.3. Хэрвээ бэлгийн хүчирхийлэлд өртөж жирэмсэлсэн тохиолдолд хууль, хяналтын байгууллагын тодорхойлолт,

3.8.4. Цусан төрөл ойртсон нь нотлогдсон хууль, хяналтын байгууллагын тодорхойлолт.

3.9. Үр хөндөлтийн дараа гарч болох хүндрэл, жирэмслэхээс сэргийлэх үр дүнтэй аргын талаарх зөвлөгөөг үйлчлүүлэгчид өгч, энэ тухай “Үр хөндөлтийн түүх”-нд тэмдэглэнэ.

3.10. Үр хөндөлтийн тухай тайланг батлагдсан маягтын дагуу сар бүр аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дүн бүртгэлийн албанд мэдээлнэ.

3.11. Эрүүл мэндийн газар мэдээллийг нэгтгэн, Эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдээлнэ.

3.12. Эмнэлгийн бус аюултай үр хөндөлтийг анхны үзлэг хийж оношилсон эмч энэ тухай Цагдаагийн ерөнхий газрын 102 тоот утсанд мэдээлнэ.

3.13. Эрүүл мэндийн байгууллага нь үр хөндөлтийн хор уршиг, ялангуяа аюултай үр хөндөлтөөс сэргийлэх талаар олон нийтэд таниулах ажлыг эрчимтэй зохион байгуулан, гарын авлага, зурагт хуудас, видео боловсруулан мэдээлэл, сургалт, сурталчилгаа тогтмол явуулна.

Дөрөв. Бусад

4.1. Эрүүл мэндийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.2 дахь хэсэг, үр хөндөлтийн тусламж, үйлчилгээний стандарт, эмнэлзүйн заавар болон энэхүү журмыг зөрчсөн нь нотлогдсон тохиолдолд “Эмчлэх, сувилах, эм барих” зөвшөөрөл болон эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгоно.